

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашбалбар сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор: Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1 Албан шаардлага	
5.2 Зөвлөмж	17
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.24 № 421.

танай _____-ны № _____-т

ДАШБАЛБАР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.БАТЗОРИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашбалбар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Дашбалбар сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дүгнээгүй байна.

011022215

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,373,884.6	2,439,880.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	885,431.2	1,698,669.5
33	АВЛАГА	266,310.9	210,082.3
34	УРЬДЧИЛГАА	-	264,127.0
35	БАРАА МАТЕРИАЛ	222,142.5	267,001.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,559,033.2	17,171,148.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,559,033.2	17,171,148.0
39100	Газар	-	73,286.0
39200	Биет хөрөнгө	15,547,710.0	16,769,684.4
39300	Биет бус хөрөнгө	11,323.2	8,587.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	319,589.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,932,917.8	19,611,028.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,932,917.8	19,611,028.0
51	Засгийн газрын хувь оролцоо	16,932,917.8	19,611,028.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	811,835.2	885,121.2
51200	Хуримтлагдсан үр дүн	15,755,353.0	18,360,177.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	365,729.6	365,729.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,932,917.8	19,611,028.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,931,755.8	14,816,849.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4,089,106.3	4,820,187.6
110	Орлогын албан татвар	3,296,930.6	4,107,493.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,306,911.8	4,164,232.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,981.2)	(56,739.4)
113	Хөрөнгийн албан татвар	590,360.7	571,928.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	201,815.0	140,765.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,875,803.2	6,226,470.5
120	Нийтлэг татварын бус орлого	9,558,279.2	5,726,470.5
121	Хөрөнгийн орлого	-	-
122	Тусламжийн орлого	317,524.0	500,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,966,846.3	3,770,191.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,429,915.1	7,667,652.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,905,589.1	2,982,153.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,905,589.1	2,982,153.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,609.0	692,676.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,715.0	80,145.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,295.8	573,284.9
2104	Хангамж, бараа материалын зардал	44,344.9	60,642.5
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,205.8	37,482.0
2107	Томилолт, зочны зардал	15,279.6	21,084.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	443,443.9	200,466.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	865,695.1	1,316,371.8

Дашбалбар сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,524,326.0	4,685,498.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,003,894.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,501,840.7	5,145,302.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,028,922.1	2,546,635.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	8,472,918.6	2,598,666.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,459,999.1		8,459,999.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,459,999.1		8,459,999.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-		-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-		-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-		-
8	Зарласан ногдол ашиг	-		-
9	Тайлант үеийн үр дүн	8,472,918.6		8,472,918.6
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,932,917.8		16,932,917.8
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,932,917.8		16,932,917.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,363,143.3)		(3,363,143.3)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,569,774.5		13,569,774.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,369,300.9		3,369,300.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	73,286.0		73,286.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
17	Өмчид гарсан өөрчилөлт			-
18	Зарласан ногдол ашиг			-
19	Тайлант үеийн үр дүн	2,598,666.6		2,598,666.6
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,611,028.0		19,611,028.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,437,540.2	10,716,633.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4,089,106.3	4,820,187.6
110	Орлогын албан татвар	3,296,930.6	4,107,493.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,306,911.8	4,164,232.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,981.2)	(56,739.4)
113	Хөрөнгийн албан татвар	590,360.7	571,928.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	201,815.0	140,765.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,643.7	6,522.0
1181	Газрын төлбөр	122,909.0	80,243.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	70,262.2	54,000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,381,827.6	2,126,254.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,064,303.6	1,626,254.8
122	Тусламжийн орлого	317,524.0	500,000.0

Дашбалбар сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,966,606.3	3,770,191.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,088,389.1	7,035,968.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,088,389.1	7,035,968.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,563,306.2	2,350,470.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	491,113.1	787,024.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,379.4	107,539.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,682.4	590,678.4
2104	Хангамж, бараа материалын зардал	109,589.2	93,947.0
2105	Нормативт зардал	-	1,204.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,205.8	46,701.4
2107	Томилолт, зочны зардал	15,279.6	21,084.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	279,628.7	20,945.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	542,428.0	681,346.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,525,082.9	4,685,498.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,349,151.1	3,680,664.9
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,018,510.8	2,867,426.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,018,510.8	2,867,426.5
2200	Дотоод эх үүсвэрээр		
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,018,510.8)	(2,867,426.5)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(168,000.0)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	168,000.0	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	162,640.3	813,238.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	722,790.9	885,431.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	885,431.2	1,698,669.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,833,335.2	4,928,804.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,592,683.3	2,076,377.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,520,167.4	2,007,812.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	881,626.2	692,676.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,361.8	80,145.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	629,720.0	573,284.9
2104	Хангамж, бараа материалын зардал	44,762.1	41,530.9
2105	Нормативт зардал	1,401.4	1,204.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,808.7	60,201.0
2107	Томилолт, зочны зардал	17,690.9	17,080.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,756.6	924.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	761,039.7	540,765.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,515.9	68,564.6

Дашбалбар сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	72,515.9	68,564.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,092,836.4	2,852,426.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	147,815.5	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,833,335.2	5,847,039.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	344,198.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,442,831.7	4,938,334.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	890,503.5	64,506.0
	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮИХ	500,000.0	500,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	369,718.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	715,442.6
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5
610001	Төсвийн байгууллага	5	5
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	25
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	12	11
620003	Үйлчлэх ажилтан	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	158,115.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	158,115.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158,115.3
2104	Хангамж, бараа материалын зардал	13,529.9
2106	Томилолт, зочны зардал	4,004.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,580.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	158,115.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,115.3

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 519.6 сая төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 519.6 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

1. Илрүүлэлт

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг 1 бодлого, 11 зорилт, 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, биелэлтийг 90.5 хувиар тайлагнасан байна. Дашбалбар сумын ИТХ нь 2024 хөгжлийн төлөвлөгөөг дүгнээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сумын ИТХ-д өгсөн зөвлөмж

2024 оны дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэл, хүрсэн үр дүнг үнэлж дүгнэх.

2. Илрүүлэлт

Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 76.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

Орон нутгийн хөрөнгө оруулалт: Тайлант онд 686.9 сая төгрөгийн 21 ажил хийхээр төлөвлөгөө батлагдсан байна. Гүйцэтгэлээр 551.6 сая төгрөгөөр 19 ажил хийгдсэн байна. Хэрэгжилт 80.3 хувь байна.

Хөрөнгө оруулалтын бус төсөл арга хэмжээ: Тайлант онд 412.9 сая төгрөгийн 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулсан байна. Гүйцэтгэлээр 343.7 сая төгрөгөөр 22 ажил хийгдэж, төлөвлөсөн арга хэмжээнүүд 83.2 хувь нь хэрэгжсэн байна.

ОНХС: ОНХС-гийн хөрөнгөөр 3,502.4 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Үүнээс 888.4 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ 30-50 хувьтай, 428.4 сая төгрөгийн 2 ажил хэрэгжээгүй байна. Тайлант оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт 65.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

3. Илрүүлэлт

Дашбалбар сумын нийт орлого ба тусламжийн дүн 94.3 хувьтай буюу нийт төлөвлөснөөс 373.8 сая төгрөгөөр дутуу биелсэн байна. Сумын татварын орлого нийт дүнгээрээ 99.6 хувиар биелсэн ч газрын төлбөр 32.1 хувь, улсын тэмдэгтийн хураамж 61.1 хувь, ус рашааны нөөц ашигласны төлбөр 83.3 хувьтай биелсэн байна. Татварын бус орлого 79.6 хувиар биелсэн нь бусад орлого буюу уул уурхайн компаниас орох ажлын байрны нөхөн төлбөр 349.9 сая төгрөгөөр тасрахад нөлөөлсөн бол татварын орлого тасрахад газрын төлбөр 169.7 сая төгрөгөөр тасарсан нь нөлөөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

зөвлөмж

Татварын орлогыг нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор

Дашбалбар сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг ИТХ нь дүгнээгүй	1	0					1	0				
Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллаагүй	1	0					1	0				
Татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлж ажиллаагүй	1	519.6					1	519.6				
Дүн	3	519.6					3	519.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
ТТЗ	1	-						1	-
Дүн	1	-						1	-

